

СУМЫН ЗАСАГ ДАРГА



БАТЛАВ

М.ЖАМЪЯНШАРАВ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ХООЛ, ХҮНСНИЙ
БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

БАТ-ӨЛЗИЙ СУМ
2019 ОН

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ БАТ-ӨЛЗИЙ СУМ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2019 оны 03 сарын 21 өдөр

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН ХООЛ, ХҮНСНИЙ МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН
САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэлчдийн
хоол, хүнсний материал нийлүүлэх тендер

Төслийн дугаар: **ӨВАБӨСЗДТГ/201901014**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019.03.21

Тендер шалгаруулалтын нэр: **Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **ӨВАБӨСЗДТГ/201901014**

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Засаг даргын тамгын газар эрх бүхий тендерт оролцогчдоос **Бат-Өлзий сумын Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэгчдийн хоол, хүнсний материал** нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай **битүүмжилсэн** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалтын журам”-ын дагуу зохион байгуулагдаж байна.

Тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой бөгөөд тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөг цахим тендерийн хураамж төлнө.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэх “45” хоног хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь: Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**

- **Борлуулалтын хэмжээ:** 2018оны борлуулалтын орлого тухайн тендерийн төсөвт өртгийн 20 хувиас багагүй байх
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь тухайн тендерийн төсөвт өртгийн 20 хувиас багагүй байх
- **Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2018 он
- **Сүүлийн нэг жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** 2017, 2018 аль нэг онд тухайн тендерийн төсөвт өртгийн 20 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байна
- **Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Тийм

Тендерийг **2019 оны 04 -р сарын 16 -ны өдрийн 11 цаг 00 минут** -аас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 -р сарын 16 -ны өдрийн 11 цаг 30 минут** -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Өвөрхангай Бат-Өлзий сумын ЗДТГ
Санхүү албаны өрөө, Утас 95089588, 99061425

Имэйл хаяг: Bat-Ulzii@ov.gov.mn

Вэб сайт: Bat-Ulzii.ov.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Дэлгүүрийн тохиролын гэрчилгээ
(д) 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, татвар, Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш “45” хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны |

дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - 2018 оны жилийн санхүүгийн тайлан /www.mof.gov.e-balance.mn цахим бүртгэлд шивэгдэн баталгаажсан байх/ - Сүүлийн /2017, 2018 аль нэг оны/ туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, акт/ - <u>Бусад нэмэлт шаардлага:</u> <ol style="list-style-type: none"> 1. ААНБайгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан байх/ 2. Сүүлийн нэг жилд ашигтай ажилласан байх /Борлуулалтын орлого тухайн тендерийн төсөвт өртгийн 20 хувиас багагүй/ 3. Харилцагч банкнуудын тодорхойлолт 4. Харъяа татвар, нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт: Татвар www.efax.mta.mn сайтыг ашиглан тодорхойлолт авч ирүүлнэ. 5. Бүтээглэхүүний шаардлага: Хугацаа дууссан бүтээгдэхүүн чанарын шаардлага хангахгүй /норсон хатсан, хөгцөрсөн, жин дутуу, гашилж ээдсэн зэрэг/ бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд хэрэглэгчийг хохиролгүй болгоно гэсэн баталгааг албан бичгээр ирүүлнэ.
	<p><u>Тендерт оролцогч нь:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл баримт бичгийг электрон хэлбэр Adobe PDF–д хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ. 2. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийн талаар санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэхэд татгагдах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан тоот ирүүлэх <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тэндерт оролцогч нь төрийн худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг PKL-ээр нэвтрэн орж материалыг цахимаар авч, тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p>
ТӨӨЗ 2.1	<p><u>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</u></p> <p>Байгууллагын хаяг: Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, 5-р баг, ЗДТГ, Санхүүгийн алба, Утас: 95089588, 99061425</p> <p>Огноо: 2019 оны 04 дугаар сарын 16 –ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах системийн /www.tender.gov.mn/-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</p>

<p>ТӨӨЗ 2.2</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын ЗДТГ, Санхүүгийн алба, Утас: 95089588, 99061425</p> <p>Огноо: 2019 оны 04 дугаар сарын 16-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 30 минут</p>
<p>ТӨӨЗ 6.1</p>	<p>Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш “45” хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь багцгүй.</p> <p>Төсөвт өртөг: <u>15 159 000</u> /Арван таван сая нэг зуун тавин есөн мянган төгрөг 00 мөнгө/</p>

Барааны тодорхойлолт:

- **Мах, дайвар бүтээгдэхүүнд:** худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн үхэр, хонины мах орно. Дотор гэдэс, толгой шийр, хамаарахгүй. Бүх төрлийн хиам авна. Лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй.
- **Сүү, сүүн бүтээгдэхүүнд:** хуурай болон шингэн сүү, тараг, аарц хамаарна.
- **Гурил, гурилан бүтээгдэхүүнд:** 1,2 дугаар гурил, ширхэгтэй гурил, бүх төрлийн гоймон, хар, цагаан талх, төрөл бүрийн боорцог, печень хамаарна.
- **Төмс, хүнсний ногоо болон нарийн ногоонд:** төмс, лууван, байцаа, хүрэн манжин, сонгино, сармис, огурцы, далайн байцаа, чинжүү хамаарна. Дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй.
- **Будаа гэдэгт:** бүх төрлийн будаа, хүүхдийн будаа, үр тариа, шар буурцгийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна.
- **Жимс, жимсгэнэ гэдэгт:** бүх төрлийн жимс жимсгэнэ, жимсний чанамал хамаарна.
- **Бусад бүтээгдэхүүн:** Өндөг, ургамлын тос, элсэн чихэр, цай, давс, цөцгийн тос, сода, хоол амтлагч, исгээгч хамаарна.

Жич : Тухайн нийлүүлж буй бүтээгдэхүүн хэвтэн эмчлүүлэгчийн тооноос шалтгаалж сар бүр хэлбэлзэлтэй байна. Хугацаа дууссан болон чанарын шаардлага хангахгүй /норсон, хатсан, хөгцөрсөн, жин дутуу, гашилж ээдсэн зэрэг/ бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд үл маргах журмаар захиалагчийг хохиролгүй болгох

Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч нь:

- ✓ Аж ахуйн нэгж
- ✓ Хүнсний дэлгүүрийн тохирлын гэрчилгээ
- ✓ Пос машинтай байх
- ✓ НӨАТ-ын баримт хэвлэгч машинтай байх
- ✓ Шаардлага хангасан хүнсний агуулах, зориулалтын хөргөгч, хөргүүртэй байх
- ✓ Үүдний хэсэгтээ тохижилт гэрэлтүүлэгтэй байх
- ✓ Жин хэмжүүр нь баталгаажсан, хугацаа дуусаагүй байх
- ✓ Ариун цэвэр, ахуйн хангамжийн өрөө, халаалтын асуудлыг шийдсэн байх
- ✓ Худалдаалж байгаа барааны нэр төрөл олон, сонголт ихтэй байх
- ✓ Барааны баталгаажилт, шинжилгээний иж бүрдэлтэй байх
- ✓ Худалдагч мэргэжлийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд улирал бүр хамрагдсан эрүүл, ажлын хувцас өмсөж хэвшсэн байх
- ✓ Захиалсан бараа бүтээгдэхүүнийг цаг тухай бүрт өөрсдийн унаагаар авч ирж байгууллагын няравд хүлээлгэн өгөх
- ✓ Бараа бүтээгдэхүүн чанарын шаардлага хангасан байх
- ✓ Үйлчилгээ үзүүлэхүйц байршил сайтай байх /энэ давуу тал болно/
- ✓ Дэлгүүр нь мэргэжлийн худалдагчтай Эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан байх
- ✓ Ажиллах хүчтэй байх /Ажилчдын талаар мэдээлэл ирүүлэх/

Стандарт: Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа худалдааны газрын болон нийлүүлэх нэр төрлийн бүтээгдэхүүний тус бүрийн стандарт, мөн бүтээгдэхүүний тээвэрлэлт, сав баглаа боодлын стандартын шаардлагыг хангасан байна.

Баглаа, боодол: Бараа нь сав баглаа, боодлын хувьд бүрэн бүтэн, стандартын дагуу хадгалагдсан, үйлдвэрлэсэн, савласан болон хадгалалтын хугацаа нь бүрэн, ойлгогдохуйц байх

Дөрөв: 1. БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭТИЙН ХУВААРЬ

Д/Д	Нэр төрөл	Хэм жих нэгж	Тоо шир хэг	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Мах /үхэр/	кг	500	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
2	Мах /хонь/	кг	500	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
3	Хиам /давхар утлагат, чанамал	кг	30	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
4	Аарц /орон нутгийн/	кг	500	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
5	Сүү /орон нутгийн/	кг	500	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
6	Сүү /үйлдвэрийн/	кг	50	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
7	Тараг /шинэ/	кг	300	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
8	Гурил /Алтан тариан гурилтай дүйцэхүйц/	кг	500	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
9	Цагаан будаа	кг	300	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
10	Шар будаа	кг	100	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
11	Гурвалжин будаа	кг	60	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	

12	Каш	кг	60	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
13	Гоймон	кг	50	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
14	Гоймон/лапша/	кг	60	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
15	Боорцог	кг	200	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
16	Жигнэмэг/Орос/	кг	150	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
17	Хар талх	ш	50	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
18	Цагаан талх	ш	120	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
19	Төмс /орон нутгийн, шинэ/	кг	500	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
20	Байцаа /орон нутгийн, шинэ/	кг	300	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
21	Далайн байцаа	кг	50	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
22	Лууван /орон нутгийн, шинэ/	ш	300	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
23	Манжин /орон нутгийн, шинэ/	кг	200	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
24	Сонгино	кг	150	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
25	Сармис	кг	20	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
26	Хүрэн манжин /орон нутгийн, шинэ/	кг	50	ЭМТөв	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-	

						ны өдөр	
27	Чинжүү	кг	50	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
28	Масло	кг	100	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
29	Элсэн чихэр	кг	120	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
30	Алим	кг	50	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
31	Майонез	кг	10	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
32	Үзэм	кг	150	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
33	Чавга	кг	30	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
34	Аньс	ш	50	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
35	Исгэгч	ш	98	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
36	Чацаргана	кг	40	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
37	Ургамлын тос	кг	80		Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
38	Өндөг /шинэ/	ш	300	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
39	Цай	ш	30	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
40	Давс	ш	55	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
41	Амтлагч	ш	50	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	

					өдрөөс	сарын 31-ны өдөр	
42	Сода	Ш	24	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	
43	Вариань	Ш	50	ЭМТөө	Гэрээ хийгдсэн өдрөөс	2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр	

Дөрөв; 2. Техникийн тодорхойлолт: Нийлүүлэх бүтээгдэхүүн нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Д/Д	Барааны нэрс	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Нэгдүгээр гурил	1. Алтан тариа үйлдвэрийн гурилтай дүйцэхүйц 2. Гадны үнэр, амтгүй, хортон шавьж, өндөг авгалдай илрэх ёсгүй 3. Ариун цэвэр эрүүл ахун шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
2	Гоймон /кг-ын/	1. Орос улс болон Алтан тариа үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц, сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн. 2. ММ30244:2009 техникийн шаардлага хангасан 3. Слава буюу Орос улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц 4. Гадны механик хольцгүй, бяцарч хуваагдаагүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй байна.
3	Гоймон /туузан 300гр-ын/	
4	Цагаан будаа	
5	Гурвалжин будаа	
6	Хүүхдийн будаа	
7	Шар будаа	
8	Шингэн сүү	
9	Хуурай сүү	1. Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь стандартын шаардлага хангасан, лабораторын бичиг, баримттай байна. 2. Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу сүүг зориулалтын саванд тээвэрлэн хүргэж ирнэ. Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь эх орны сүүн бүтээгдэхүүн байна.
10	Аарц	1. Монгол аргаар бэлтгэгдсэн шинэ /хог хаягдал, шавьж хорхойгүй/ 2. Цагаан өнгөтэй, хэт исгэлүүн, ахарсан, хөгцөрсөн биш, хэт амтгүй биш, өтгөн
11	Тараг	
12	Үзэм	1. Орос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц байна. 2. Тээвэрлэлтийн явцад гэмтэж, муудаагүй байх 3. Эх орны хөрсөнд ургасан, Орон нутагт тариалагдсан бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц 4. Ялзарч муудаагүй шинэ, хадгалат сайтай байна
13	Алим	
14	Чавга	
15	Аньс	
16	Чацаргана	
17	Төмс	
18	Байцаа	
19	Манжин	

20	Лууван	3. Тус, тусдаа савлагдсан, хуурай байх 4. Чулуу, шорооны хольцгүй 5. Гадны үнэр ороогүй байх
21	Сонгино	
22	Сармис	
23	Чинжүү	
24	Хүрэн манжин	
25	Баахуу цай	1. Бүтээгдэхүүн тус бүр зориулалтын саванд садлагдсан 2. Тээвэрлэлтийн явцад гэмтэж, муудах, хагарч асгарахаас хамгаалагдсан байна. 3. Их тайга болон түүнтэй дүйцэхүйц
26	Майонез	1. Орос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц 2. Гадны үнэр амтгүй, нэр төрөлдөө тохирсон өнгөтэй ,стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байх
27	Масло	
28	Ургамлын тос	
29	Сахар	
30	Давс	1. Монгол улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц байна.
31	Далайн байцаа	1. Солонгос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц 2. Сав баглаа, боодол бүрэн бүтэн байх
32	Варень	1. Варень MNS 6308:2012 стандартын дагуу бэлтгэсэн нэрс, гүзээлзгэнэ, аньс, үхрийн нүдний чанамал байх ба эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
33	Амтлагч	1. Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн байна 2. Бүтээгдэхүүний хугацаа дуусаагүй, хугацааг харахад ойлгомжтой байх
34	Перец	
35	Укроп	
36	Сода	
37	Исгээч	
38	Үхрийн мах	1. Стандартын шаардлага хангасан гарал үүсэл, шинжилгээний бичигтэй байна 2. Мах нь шинэ, чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэж, гадаргуу цэвэр, цэвэр, гадны үнэр амтгүй /шивтэр, бензин гэх мэт үнэргүй, хэвлийн хөндийд дайвар бүтээгдэхүүн болон малын ялдагдасгүй байх 3. Хонины гулууз 20 кг-аас дээш байх
39	Хонины мах	
40	Хуам	1. Стандартын шаардлага хангасан Эх орны үйлдвэрийн, “Очир дагинас ХХК”-ын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц 2. Бүтээгдэхүүний чанар, өнгө гардаргуу цэвэр байх 3. Үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа тодорхой байх 4. Үйлдвэрийн шинжилгээний бичигтэй байх
41	Өндөг	1. Лабораторын шинжилгээний бичигтэй байх 2. Үйлдвэрлэсэн хугацаа тодорхой байх 3. Орос өндөгтэй дүйцэхүйц
42	Боорцог	1. Бүтээгдэхүүний чанар хэлбэр, өнгө, гадаргуу, амт үнэр зэрэг нь стандартын шаардлага хангасан үйлдвэрт баталгаажсан, жор технологийн зааврыг баримтлан үйлдвэрлэсэн байх ба “Дэлгэрэх хүнс” ХХК-ын үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц байх 2. Сайн чанарын дотоодын үйлдвэрийн эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн эсвэл Орос улсад үйлдвэрлэгдсэн печеньтэй дүйцэхүйц хэлбэр дүрс, амт чанар сайтай жигнэмэг байх
43	Талх /хар/	
44	Талх /цагаан/	
45	Жигнэмэг	

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

<i>Д/Д</i>	<i>Нэр төрөл</i>	<i>Тодорхойлолт</i>	<i>Барааны гарал үүслийн улс</i>	<i>Тоо ширхэг</i>	<i>Нэгж үнэ</i>	<i>Нийт үнэ</i>	<i>НӨАТ болон бусад албан татвар</i>	<i>Бүгд дүн</i>
1	Мах /үхэр/							
2	Мах /хонь/							
3	Хиам /давхар утлагат, чанамал							
4	Аарц /орон нутгийн/							
5	Сүү /орон нутгийн/							
6	Сүү /үйлдвэрийн/							
7	Тараг /шинэ/							
8	Гурил /Алтан тариан гурилтай дүйцэхүйц/							
9	Цагаан будаа							
10	Шар будаа							
11	Гурвалжин будаа							
12	Каш							
13	Гоймон							
14	Гоймон/лапша/							
15	Боорцог							
16	Жигнэмэг/Орос/							
17	Хар талх							
18	Цагаан талх							
19	Төмс /орон нутгийн, шинэ/							
20	Байцаа /орон нутгийн, шинэ/							
21	Далайн байцаа							

22	Лууван /орон нутгийн, шинэ/							
23	Манжин /орон нутгийн, шинэ/							
24	Сонгино							
25	Сармис							
26	Хүрэн манжин /орон нутгийн, шинэ/							
27	Чинжүү							
28	Масло							
29	Элсэн чихэр							
30	Алим							
31	Майонез							
32	Үзэм							
33	Чавга							
34	Аньс							
35	Исгэгч							
36	Чацаргана							
37	Ургамлын тос							
38	Өндөг /шинэ/							
39	Цай							
40	Давс							
41	Амтлагч							
42	Сода							
43	Вариань							
Тендерийн нийт үнэ								

Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээцүцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[моо]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[моо]**
- Алдангийн нийт дүн: **[моо]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.
⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]